



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/2/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Н.Хулансүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: khulansuren@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв.....	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж.....	16

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025-02-25 № 63

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолон тэмдэглэсэн хэсэг

Зорилтот бүлгийн иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, цахим худалдааг хэрхэн хийх, цахим халдлагаас хэрхэн сэргийлэх талаар Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Цахим хөгжлийн хэлтэстэй хамтран 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр 2 удаагийн сургалт, үзэсгэлэн худалдаагаар 58 иргэнийг хамруулж, санхүүгийн тайланд тодруулж толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 283,515.0 мянган төгрөгийг төлөвлөж, зарцуулсан ба нийт 195 иргэн хамрагдаж, шинээр 75 иргэн ажлын байртай болсон байна.

4525020244

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 80.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,276,590,585.00</u>	<u>2,222,905,795.32</u>
33	АВЛАГА	2,276,590,585.00	2,222,905,795.32
33300	Татаас, санхүүжилтийн авлага	314,332,016.00	-
335	Бусад авлага	1,962,258,569.00	2,222,905,795.32
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,962,258,569.00	2,222,905,795.32
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,276,590,585.00</u>	<u>2,222,905,795.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,276,590,585.00</u>	<u>2,222,905,795.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,276,590,585.00	2,222,905,795.32
512	Хуримтлагдсан үр дүн	2,276,590,585.00	2,222,905,795.32
51210	Өмнөх үеийн үр дүн	2,276,590,585.00	2,276,590,585.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(53,684,789.68)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,276,590,585.00</u>	<u>2,222,905,795.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,963,546,000.00	2,301,414,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,812,616,000.00	2,301,414,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,812,616,000.00	2,301,414,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,812,616,000.00	2,301,414,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,824,200.00	944,551,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	220,797,000.00	129,960,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	940,994,800.00	1,226,902,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	150,930,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	137,930,000.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	137,930,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,252,981,174.00	2,355,099,289.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,252,981,174.00	2,355,099,289.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,558,237.00	115,039,959.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,558,237.00	115,039,959.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,558,237.00	115,039,959.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,155,422,937.00	2,240,059,330.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	529,267,468.00	479,691,946.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	529,267,468.00	479,691,946.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	525,054,611.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	525,054,611.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	81,740,000.00	129,960,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,740,000.00	129,960,000.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,000,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	544,415,469.00	1,105,352,773.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	544,415,469.00	1,105,352,773.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	710,564,826.00	(53,684,789.68)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	710,564,826.00	(53,684,789.68)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,963,546,000.00</u>	<u>2,615,746,516.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,812,616,000.00	2,615,746,516.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,812,616,000.00	2,615,746,516.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,812,616,000.00	2,615,746,516.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,824,200.00	944,551,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	220,797,000.00	129,960,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	940,994,800.00	1,541,234,916.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>150,930,000.00</u>	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	137,930,000.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	137,930,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,531,313,190.00</u>	<u>3,721,099,289.68</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,531,313,190.00	3,721,099,289.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,558,237.00	115,039,959.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,558,237.00	115,039,959.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,558,237.00	115,039,959.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,433,754,953.00	3,606,059,330.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,493,267,468.00	1,845,691,946.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,493,267,468.00	1,845,691,946.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	298,980,295.00	525,054,611.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	298,980,295.00	525,054,611.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	81,740,000.00	129,960,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,740,000.00	129,960,000.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,000,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	559,767,190.00	1,105,352,773.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	559,767,190.00	1,105,352,773.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(567,767,190.00)</u>	<u>(1,105,352,773.68)</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	=
14	Бусад эх үүсвэр	567,767,190.00	1,105,352,773.68
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	567,767,190.00	1,105,352,773.68
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>567,767,190.00</u>	<u>1,105,352,773.68</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөвц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	1,574,003,369.00	-	1,574,003,369.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,797,550.00)	-	(7,797,550.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,566,205,819.00	-	1,566,205,819.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	710,564,826.00	-	710,564,826.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,276,590,585.00	-	2,276,590,585.00
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	2,276,590,585.00	-	2,276,590,585.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,276,590,585.00	-	2,276,590,585.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(53,684,789.68)	-	(53,684,789.68)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,222,905,795.32	-	2,222,905,795.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,518,786,516.00	2,308,063,921.00	(210,722,595.00)	91.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,518,786,516.00	2,308,063,921.00	(210,722,595.00)	91.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,500,000.00	115,039,959.00	(23,460,041.00)	83.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,500,000.00	115,039,959.00	(23,460,041.00)	83.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138,500,000.00	115,039,959.00	(23,460,041.00)	83.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,380,286,516.00	2,193,023,962.00	(187,262,554.00)	92.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,380,286,516.00	2,193,023,962.00	(187,262,554.00)	92.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,032,954,500.00	1,845,691,946.00	(187,262,554.00)	90.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	347,332,016.00	347,332,016.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,518,786,516.00	2,405,023,921.00	(113,762,595.00)	95.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,518,786,516.00	2,405,023,921.00	(113,762,595.00)	95.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	944,551,600.00	944,551,600.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,000,000.00	129,960,000.00	96,960,000.00	393.8
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,541,234,916.00	1,330,512,321.00	(210,722,595.00)	86.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хариуцдаг сан юм.

Тус байгууллага нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэсэн зорилгын хүрээнд 2024 онд “Иргэндээ үйлчилдэг төрийн албаны соёлыг төлөвшүүлнэ” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сан нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны А/174 дугаар тушаалаар баталж, мөрдөж эхэлсэн байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,222,905.8 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,276,591.6	2,222,905.8	(53,685.8)
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	2,276,591.6	2,222,905.8	(53,685.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,276,591.6	2,222,905.8	(53,685.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,276,591.6	2,222,905.8	(53,685.8)

Авлага данс тайлант онд олгосон 1,366,000.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, эргэн төлөлтөөс орж ирсэн 1,105,352.8 мянган төгрөг, өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 314,332.0 мянган төгрөгийг ерөнхий газарт төвлөрүүлснээр тайлант оны эцэст 2,222,905.8 мянган төгрөгийн авлага тусгагджээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,222,905.8 мянган төгрөг болж, 53,685.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 2,232,429.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 40,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 922,093.5 мянган төгрөгөөр бууруулж, 1,350,335.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг 208,960.0 мянган төгрөгөөр нэмж, бусад хөтөлбөрийг нийт 1,131,053.5 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 1,168,451.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 2,518,786.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2024 онд засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг 190,000.0 мянган төгрөгөөр бууруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаагүй төлбөрийн орлогын төвлөрүүлэлтийг 33,000.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн урьд оны үлдэгдэл төвлөрүүлэлтийг 314,332.0 мянган төгрөгөөр, бусад арга хэмжээний зардлыг 1,011,119.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээ санхүүжүүлэх 2,171,454.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр, 33,000.0 мянган төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрөөс, 314,332.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авсан 2,171,454.5 мянган төгрөгийн санхүүжилтээс 1,960,731.9 мянган төгрөгийг зарцуулж, санхүүжилтээс үлдсэн 210,722.6 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулаагүйн орлого 129,960.0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн урьд оны үлдэгдэл 314,332.0 мянган төгрөг, нийт 655,014.6 мянган төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөтөлбөр арга хэмжээний зардлын гүйцэтгэл 2,308,063.9 мянган төгрөг буюу 91.6 хувьтай байгаа нь төлөвлөгөөнд тусгагдсан 3 хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах иргэдийн тооны гүйцэтгэл, сонгуулийн саруудад сангийн данс битүүмжлэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2,518,786.5	2,308,063.9	(210,722.6)	91.6
1.1	80224-Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4,500.0	1,531.6	(2,968.4)	34.0
1.2	82602-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих	292,369.0	283,515.0	(8,854.0)	97.0
1.3	82616-ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл	18,960.0	10,000.0	(8,960.0)	52.7
1.4	82619-Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	38,005.5	37,771.5	(234.0)	99.4
1.5	82620-Хөдөлмөрт бэлтгэх сургалт	103,040.0	74,600.0	(28,440.0)	72.4
1.6	82621-Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	1,399,940.0	1,333,685.4	(66,254.6)	95.3
1.7	82622-Түр ажлын байрыг дэмжих	180,640.0	106,120.0	(74,520.0)	58.7
1.8	82623-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	134,000.0	113,508.4	(20,491.6)	84.7
1.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулаагүйн орлого төвлөрүүлэлт	33,000.0	33,000.0	-	100.0
1.10	Өмнөх оны үлдэгдэл төвлөрүүлэлт	314,332.0	314,332.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 115,040.0 мянган төгрөг төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулжээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Н.Хулансүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 54 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,518,786.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,187.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 26 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 3 мэдээлэл бүхий 1,994,200.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроосон, 2 мэдээлэл бүхий 16,510.0 мянган

төгрөгийн мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус сангийн өмнөх оны аудитаар өгсөн 5,570.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн биелэлтийг шалгахад 100 хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,570.0	2	5,570.0	100.0
Нийт дүн	2	5,570.0	2	5,570.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Тайлангийн 4.4.1-т дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3 мэдээлэл бүхий 1,994,200.0 мянган төгрөгийн мэдээллийг хоцроосон, 2 мэдээлэл бүхий 16,510.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.	1	2,010,710.0	-	-	-	-	1	2,010,710.0
Дүн	1	2,010,710.0	-	-	-	-	1	2,010,710.0